

**Нислэгийн цаг уурын төвийн
2019 оны 09 дүгээр сарын ажлын тайлан**

2019.10.07

1.Зорилт:

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавьж, 40 ажил хийж гүйцэтгэхээр төлөвлөн гүйцэтгэл 98.8 хувьтай байна.

2. Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 09 дүгээр сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ 197, урт хугацааны урьдчилсан мэдээ 125, районы урьдчилсан мэдээ 202, угталтын урьдчилсан мэдээ 171, өндрийн салхины урьдчилсан мэдээ 235, аэродромын урьдчилсан мэдээ 60, SIGMET 29, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 205, Тосонцэнгэл нисэх буудал орчмын TAF 76, Ханбумбат нисэх буудал орчмын TAF 151, Овоот нисэх буудал орчмын TAF 18, бусад нисэх буудал орчмын урьдчилсан мэдээ 77 удаа тус тус гаргаж, олон улсын 1067, орон нутгийн 735, онцгой ба тусгай үүргийн 34 нислэгийг 452 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын бусад төрлийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Төв орон нутгийн 6248 бодит мэдээ, 2344 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 9 дүгээр сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Нөхцөл бүрдсэн үед суултын урьдчилсан мэдээ, SIGMET мэдээ 29 зохиож, “Аюулгүйн бүс”-ээс дамжуулсан 5 AIRMET мэдээ, Агаарын хөлгийн ажиглалтын мэдээ 3-ыг хүлээн авч мэдээ зохиолтонд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилан мэдээлэх систем /WAFS/-ын бүтээгдэхүүнүүд хэвийн.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ 1380 зохиосон. Буянт-Ухаа орчмын уур амьсгалын горимын ажиглалтыг мэдээ солилцооны АК-01 коодын дагуу 240 мэдээ зохиож, УЦУОСМХ-д дамжуулсан. Уур амьсгалын ажиглалтын мэдээг 2018 оны 09 сартай харьцуулахад 1,4 хувиар буурсан. 9 дүгээр сарын уур амьсгалын горимын ажиглалтыг материалыг цахим тооцоолуурт оруулан боловсруулж, тайланг Улаанбаатар УЦУОШТ-д хүргүүлж, хариу зааварчилгаа авч ажилласан.

Ус, цаг уур, орчны ажиглалтын мэдээ дамжуулах, хяналт тавих системээр климат мэдээ 1, сарын дундаж мэдээ 1, 10 хоногийн дундаж мэдээ 3 тус тус зохион дамжуулж ажиллалаа. Иргэний нисэхийн дүрэм-174-ийн шаардлагад нийцүүлэх, Цаг уурын автомат станцуудын хэмжлийн үр дүнг харьцуулан хянасан 23 харьцуулсан ажиглалт хийж гүйцэтгэсэн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Нисэх баг, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба болон бусад харилцагч байгууллагуудад цаг агаарын талаар зөвлөгөөг цахимаар болон утсаар тогтмол өгч байна. Даваа, Лхагва, Пүрэв гарагт 7 хоногийн ажлын дүнг мэдээлж, 7 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээ, төлөв, цаг агаарын зураг, нислэгийн саатал гарсан үеийн мэдээний таарцыг дүгнэн ИНЕГ-ын болон ЦУОШГ-ын шуурхайд бэлтгэж, төвийн цахим хуудсанд нисэх буудлуудын цаг агаарын 7 хоногийн төлөв, шинэ мэдээ мэдээллийг байршуулан хэрэглэгчдэд үйлчилсэн.

Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн зөвлөмжийн дагуу Токиогийн галт уулын үнсний зөвлөмжийн төвөөс нийт 96 SIGMET мэдээ хүлээн авч МИАТ ХК, Аэромонголиа ХХК, Хүннү эйр ХХК-ийн нисэхийн цахилгаан холбооны сүлжээгээр дамжуулсан ба синоптик инженерүүдийн өдөр тутмын хийсэн ажлын судалгаанд галт уулын үнсний SIGMET 130 мэдээ хүлээн авсан, дамжуулсан бүртгэлийг тогтмол хөтөлж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 1,22%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 0,3%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 9 дүгээр сард нийт 22 нислэгийн саатал гарсан байна. Үүнд: мэдээ таарсан 19, таараагүй урьдчилсан мэдээ 3, /2018 оны 09 сард 61 саатал гарснаас 42 таарсан, 19 таараагүй./

Орон нутгийн нисэх буудлуудын буудал орчмын бодит болон урьдчилсан мэдээ, чиглэлийн урьдчилсан мэдээ, нисэх буудал орчмын 7 хоногийн төлөвт хяналт шалгалт хийж, 3 удаа хариу зааварчилгаа хүргүүлсэн. Өдөр бүр хяналтыг тавьж, тухай бүрд нь залруулах арга хэмжээ авч ажилласан. Орон нутгийн УЦУОШТ-үүдэд:

1. Нислэгийн цаг уурын мэдээний хангалт үйлчилгээтэй холбоотой гарсан зөвлөмж, шаардлагуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах;
2. Нисэх буудал орчмын урьдчилсан мэдээг Нислэгийг цаг уурын мэдээгээр хангах журам 1 дүгээр дэвтрийн Нэмэлт 10-ын дагуу дүгнэж таарцын зөрөөг арилгах талаар арга хэмжээ авч ажиллах;
3. Бодит болон урьдчилсан мэдээг зохиож дамжуулж байгаа цаг болон форматын алдаа гаргахгүй байх;
4. Агаарын хөлгийн ажиглалт /Борт/ болон AIRMET мэдээг авч мэдээ зохиолтонд ашиглах;
5. Баян-Өлгий аймгийн УЦУОШТ хөөрөлтийн урьдчилсан мэдээг бичиж хэвших шаардлагатай байгаа талаар зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутагт: Цаг агаараас шалтгаалж нийт 13 нислэг саатсан. Районы цаг агаараас шалтгаалж 11, Булган-Улаанбаатар чиглэлд салхитай, үүлтэй хүлээсэн 1, Улаанбаатар-Өлгийн чиглэлд салхитайгаас хүлээсэн байна.

3. Удирдлага, зохион байгуулалт санхүү:

ЦУОШГ болон ИНЕГ хооронд 2017 оны 10 сарын 06-ны өдөр байгуулсан “Нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх, мэдээг хэрэглэх талаар хамтран ажиллах ерөнхий гэрээ” 2 жилийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан орон нутгийн УЦУОШТ-дээс санал авч ЦУОШГ-т ажлын хэсгээр хэлэлцсэн. Саналууд нь ЦУОШГ-ын хүлээх үүрэгтэй холбоотой байсан тул ИНЕГ-т гэрээнд оруулах саналгүй, сунгах талаар албан тоот хүргүүлсэн. Гэрээг дүгнэх сунгах талаар акт үйлдэж 2 жилээр сунгахаар тохирсон.

09 сарын 17-нд ДЦУБ-аас “Монгол улсын нислэгийн цаг уурын үйлчилгээг шинэчлэн сайжруулах төсөл”-тэй холбоотой агуулга, төслийн шалгуур үзүүлэлтүүдийн шалгах хуудас, аянга цахилгааныг илрүүлэх мэдрүүрийн техникийн тодорхойлолт баримт бичгүүдийг ирүүлснийг хүлээн авч хариу хүргүүлсэн. ДЦУБ-аас ирүүлсэн “Монгол улсын нислэгийн цаг уурын үйлчилгээг шинэчлэн сайжруулах төсөл”-ийн агуулгын концепцийн тэмдэглэлийг орчуулж холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

09 сарын 18-нд БНХАУ-ын Нислэгийн хөдөлгөөний менежментийн товчоо (ATMB)-ны харьяа Нислэгийн цаг уурын төв (AMC)) -өөс “Монгол улс ба БНХАУ хоорондын SIGMET хамтын ажиллагааны зохицуулалт”-ын Гэрээний бичгийг хийхээс өмнө уулзалт зохион байгуулах талаар и-мэйл ирсэн.

Нислэгийн журам боловсруулалтын албанаас “Чингис хаан” ОУНБ-ын алсын барааны харагдацын хязгаарлалыг 1600м байсныг 2800м болгож өөрчлөх гэж байгаатай холбогдуулан МИАТ компаниас хүсэлт тавьсны дагуу 2016-2019 оны 11, 12, 1, 2 саруудын бодит ажиглалтын мэдээнд алсын барааны харагдацын давтагдалыг цагаар нарийвчлан гаргах боловсруулалтын ажлыг хийж байна.

Иргэний нисэхийн дүрэм 174-ийн шинэчлэгдсэн хувилбарын төсөлтэй танилцаж судлаад, санал боловсруулан 9 сарын 30-нд НААХЗА-ны Дүрмийн боловсруулалтын хэлтсийн rule@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.

9 сарын 05-нд ЦУОШГ-аас Өвөрхангай аймгийн Хужирт станцын сүүлийн 5 жилийн мэдээг хүлээн авч НБУГ-ын мэргэжилтэн П.Ганболдын pu_qanbold@mcaa.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.

09 дүгээр сарын 20-нд зохион байгуулагдсан “Хандлагаа өөрчилъе” уриалга дэвшүүлсэн БОАЖ-ын салбарын “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгт ЕТИ Б.Сүхбаатар, СМТИ Аюушжав, СМСИ А.Баярмаа нар оролцож төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан.

9 дүгээр сарын 11-ний өдөр алсын барааны харагдацын баруун хойдын 1000 метрийн самбарыг стандартын дагуу будсан.

Улсын төв комиссын даргын баталсан байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивыг дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу ажлаа дүгнэж, ЦУОШГ-ын Тайлан, дүн мэдээ хариуцсан мэргэжилтэнд цахимаар хүргүүлсэн.

9 дүгээр сарын 25-нд ЦУОШГ-ын даргын А/249 дүгээр тушаалаар орон тоог 58 болгон нэмж, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт батлагдсан.

9 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн УЦУОШТ болон нисэх буудлын мэдээлэл үйлчилгээний ажилд төлөвлөгөөт үзлэг шалгалт явуулсан.

10 дугаар сарын 01-нд 9 дүгээр сарын байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд оруулсан.

Төвийн даргын Б тушаалууд 6 гарсан. Гадагш албан 22 тоот хүргүүлсэн. Гаднаас ирсэн 9 албан тоот ирүүлсэн.

“Одкон холдинг” ХХК-тай дулааны тоолуур суурилуулах гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн.

ХУД-ийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн байцаагчийн актын дагуу ээлжийн амралтын нөхөн олговрыг ажилтнуудад олгосон.

Улаанбаатар дулааны сүлжээ компанитай дулаанаар хангуулах гэрээ байгуулсан.

9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын тайлан гаргасан. Тогтмол зардлын гүйлгээнүүд хийгдсэн.

9 дүгээр сарын 15-ны өдөр Олон улсын аэродромд тавигдах шаардлагын дагуу Нислэгийн цаг уурын өртөөний байрыг будаж засварласан.

4. Сүлжээ, тоног төхөөрөмжийн талаар:

9 дүгээр сарын 27-ны өдөр өндрийн салхи 12,18 цагийн өндрийн салхи бодогдоогүй. 29-нд радарын станцын цаг 1 цагаар хоцорч орсон байсан. 28-ны 20.14 цагт мэдээ орохгүй болсныг 30-нд reset хийж 10.14 цагт хэвийн ажиллагаатай болсон.

10 дугаар сарын 01-ний өдрийн 10.00 цагаас нисэхийн цахилгаан холбооны сүлжээ /AFTN/-нд гэмтэл гарч 21.40 цагт хэвийн ажиллагаатай болсон. Энэ хугацааны мэдээнүүд AFTN сүлжээгээр дамжигдаагүй. ИНЕГ-ын Холбоо, навигаци ажиглалтын албанаас AFTN үйлчилгээний талаар тодорхойгүй хугацаагаар NOTAM мэдээ зарлагдсан тул хэрэглэгч авиакомпаниудын цахим хаягуудыг цуглуулж, цахим шуудангаар TAF METAR мэдээ хүргүүлж байх талаар албан тоот төвийн amc@mcaa.gov.mn хаягаар хүргүүлсэн. УЦУОСМХ-ийн тооцолонгийн инженерүүдтэй холбогдон цаг уурын мэйл сервер /OUTLOOK/-ээр дамжуулсан мэдээллийг олон улсад дамжуулах туршилт хийж, дамжуулсан.

Video Conference-ын төхөөрөмж ЦУОШГ-аас хуваарилсныг суурилуулсан.

Өндрийн салхины зураг мэдээ боловсруулдаг программ хангамжийг шинэчилж, өдрийн 4 удаа бодолт хийж, зургийн нарийвчлалыг 1 градус байсныг 0,5 градус болгосон, салхины мэдээ дамжуулдаг и-мэйл хаягийг amc.synoptic@gmail.com болгож өөрчилсөн .

Цаг уурын тоон загвар ажиллуулах сервер компьютер дээр цаг агаарын тоон прогнозын шинэчлэгдсэн WRF загварыг суулгаж дууссан, загварын бодолт өдөрт 4 удаа (00, 06, 12, 18) шинэчлэгдэж, бодолтын үр дүн хэвийн явагдаж байгаа. GRADS программыг судалж байна. Мөн NCEP-н эх мэдээг өндрийн салхины мэдээ боловсруулдаг машин руу өдөрт 4 удаа автоматаар шидэх тохиргоог хийсэн.

Вэб сайт шинэчлэх ажил хийгдэж, зарим өөрчлөлтийг туршиж байна.

AWS 310, AWS330 цаг уурын автомат станцын 2019 оны 8 сарын мэдээг Архив, мэдээллийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

9 дүгээр сарын 5-нд төвийн хэмжээнд 2 компьютер, нэмэлт 5ш SSD хард диск авч шаардлагатай процессорт суурилуулсан.

ЦУОШГ-аас 1 ширхэг I5 маркийн иж бүрэн компьютер авч Морин-Уул локаторын станцад суурилуулсан.

9 дүгээр сарын 25-нд Морин-Уул локатор, цаг уурын станцын AWS330 цаг уурын автомат станцад БОХТЛ-иос хэмжилт баталгаажуулалт хийсэн.

5. Сургалт, дадлага:

ИНЕГ-аас зохион байгуулсан “Хүний хүчин зүйлийг SSP/Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны үндэсний хөтөлбөр/ болон SMS /Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо/-той уялдуулах нь” сэдэвт сургалт семинарт мэргэжилтнүүд оролцсон.

Булган, Хөвсгөл, Дорнод аймгийн УЦУОШТ-үүдэд синоптик инженер, техникчид үйлдвэрлэлийн дадлага хийсэн.

Дорнод аймгийн УЦУОШТ-ийн техникч Г.Янжмаа Нислэгийн цаг уурын өртөөнд үйлдвэрлэлийн дадлага хийсэн.

БОАЖЯ-аас зохион байгуулсан “Санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх” 2 өдрийн сургалтад нягтлан бодогч оролцсон.

Дүгнэлт:

2019 оны 9 дүгээр сард олон улсын 1067, орон нутгийн 735, онцгой ба тусгай үүргийн 34 нислэгийг 452 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц: Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 1,22%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 0,30%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нислэгийн саатлын хувьд 9 дүгээр сард нийт цаг агаараас шалтгаалж нийт 22 саатал гарсан байна. Үүнээс таарсан 19, таараагүй 3, саатсан нислэгийг 86.3%-тай урьдчилан мэдээлж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.4%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 9 дүгээр сарын ажил “Хэвийн” явагдсан.